


**ХҮНИЙ БИЕД УЧИРСАН ГЭМТЛИЙН ЗЭРЭГ ТОГТООХ ШҮҮХ
ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭГ СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН
МАТЕРИАЛААР СУДАЛСАН ДҮН**

**THE RESULTS OF THE FORENSIC EXAMINATION OF THE DEGREE OF
INJURY CAUSED TO THE HUMAN BODY, BASED ON THE MATERIAL OF
THE LAST 5 YEARS**



Ц.Нандинцэцэг

*Дотоод хэргийн их сургуулийн
Шинжлэн магадлах институтын
Байгалийн ухаан техник зүйн шинжилгээний
тэнхимийн багш, цагдаагийн ахмад*



Б.Ундармаа

*Клиникийн профессор, тэргүүлэх зэргийн эмч,
анагаах ухааны магистр, цагдаагийн хошууч*



Б.Долгормаа

*Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн,
Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын тэргүүлэх
зэргийн эмч, анагаах ухааны магистр, цагдаагийн ахмад*

Товч утга: Шүүх эмнэлгийн шинжилгээний үндсэн объект бол амьд хүнд хийгдэх шинжилгээ бөгөөд шинжээч эмч хүний биед учирсан гэмтэл, гэмтлийн зэргийг тогтоох, бэлгийн холбогдолтой асуудал болон нас тогтоох, хүйс тогтоох,

эрүүл мэндийн байдлыг тогтоох зэрэг шинжилгээнүүдийг хийж, шинжээчийн дүгнэлт гаргадаг.

Сүүлийн жилүүдэд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хүний эрүүл мэндэд хүнд болон хүндэвтэр, хөнгөн хохирол учруулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зэрэг гэмт хэрэг, мөн зам тээврийн осол гэмтэл ихэссэнээр шүүх эмнэлэгт хийгдэх хүний биед учирсан гэмтлийн зэргийг тогтоох шинжилгээ нэмэгдсээр байна.

Бид ШШЕГ-ын сүүлийн 5 жилийн материалаар хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг тоон үзүүлэлтээр нарийвчлан судлах, Улаанбаатар хотод ШШЕГ-т болон аймгуудын ШША-нд хийгдсэн хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоон үзүүлэлтийг харьцуулан судлахыг зорилоо.

Түлхүүр үгс: Залуучууд, гэр бүл, шилжилт, хөдөлгөөн, хил хамгаалах байгууллага.

Abstract: The main purpose of the forensic examination is to conduct an examination of a living person, and the expert doctor makes an expert opinion by determining the degree of injury and damage to the human body, sexual problems and determining the age.

In recent years, crimes against the inviolability of human health, serious or minor damage to human health, family violence, and the increase in traffic accidents have resulted in the number of tests to determine the degree of injury to the human body.

We aim to conduct a detailed quantitative analysis of the assessment of the degree of injury caused to the human body using the materials of the last 5 years of the National Health Service, and to compare the quantitative indicators of the analysis of the degree of injury caused to the human body in the city of Ulaanbaatar and the National Health Service of the provinces.

Keywords: Injury to the human body, degree of injury, statistics.

Судалгааны зорилго: ШШҮХ-ийн сүүлийн 5 жилийн материалаар хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний өсөлт, бууралт, нас, хүйсийн байдал, гэмтэл үүсгэсэн шалтгаан, төрөл болон гэмтлийн зэргийг тогтоосон тоон үзүүлэлт, ШЭШГ ба аймгуудын ШША-ны гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоон үзүүлэлтийг харьцуулан судлахад оршино.

Судалгааны зорилт:

1. ШШҮХ-нд хийгдэж буй шинжилгээнд шүүх эмнэлгийн шинжилгээний эзлэх хувь, ШЭШГ ба аймгийн албадад хийгдсэн хүний биед учирсан гэмтлийн

зэргийг тогтоох шинжилгээний тоон үзүүлэлт, хувь хэмжээ, өсөлт, бууралтыг судлах

2.ШЭШГ-т хийгдсэн хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг нас, хүйсийн байдлаар судлах

3.ШЭШГ-т хийгдсэн хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг гэмтэл үүсгэсэн шалтгаан, төрлөөр нь судлах

4.ШЭШГ-т болон аймгуудын ШША-нд хийгдсэн хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг гэмтлийн зэрэг тогтоосон байдлаар нь харьцуулан судлах

5.Сүүлийн 5 жилийн хугацаанд Улаанбаатар хотод гарсан Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоон үзүүлэлтийг нийслэлийн 9 дүүргийн цагдаагийн газар, хэлтсээр нь харьцуулан судлах

Судалгааны арга зүй:


Улаанбаатар хотод болон аймгуудын шүүхийн шинжилгээний албадад хийгдсэн шүүх эмнэлгийн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний сүүлийн 5 жилийн материалд судалгаа хийж, судалгааны зорилтын дагуу тоон үзүүлэлтийг гарган, статистик боловсруулалт хийж, график байгуулав.

Хүснэгт №1 ШШҮХ-д сүүлийн 5 жилд хийгдсэн шинжилгээний тоон үзүүлэлт

Он Үзүүлэлт	2017		2018		2019		2020		2021		Нийт
	тоо	хувь	тоо	хувь	Тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	
ШШЕГ-д хийсэн нийт шинжилгээ	65525		69119		69710		64369		58424		32714 7
Шүүх эмнэлгийн нийт шинжилгээ	380 90	58. 1	397 79	57. 6	4015 5	57. 6	369 74	57. 4	336 31	57. 6	18862 9 (57.7 %)
ШЭШГ-т хийсэн нийт шинжилгээ	214 15	56. 2	221 24	55. 6	2257 2	56. 2	203 93	55. 2	190 47	56. 6	10555 1 (56%)
Гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	153 88	71. 9	146 27	66. 1	1461 7	64. 8	135 32	66. 3	119 27	62. 6	70091 (66.4 %)

Аймгуудын ШША-нд хийсэн нийт шинжилгээ	166 75	43. 8	176 55	44. 4	1758 3	43. 8	165 81	44. 8	145 84	43. 4	83078 (44%)
Гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	125 46	75. 2	128 66	72. 9	1252 1	71. 2	123 87	74. 7	110 22	75. 6	61342 (73.8 %)


График №1. ШШҮХ-д сүүлийн 5 жилд хийгдсэн шинжилгээний тоон үзүүлэлтийг графикаар дүрсэлбэл:



Дээрх хүснэгт №1, график №1-ээс харахад сүүлийн 5 жилд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд нийт 327147 шинжилгээ хийгдсэнээс 57.7% нь Шүүх эмнэлгийн шинжилгээ байна. Шүүх эмнэлгийн нийт шинжилгээний 56% нь Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт, 44% нь аймгуудын шүүхийн шинжилгээний албадуудад хийгджээ. Мөн 2017 онд хийгдсэн шинжилгээний тоог харьцуулан судлахад 2021 онд ШШҮХ-нд хийгдсэн шинжилгээний тоо болон ШЭШГ, аймгийн ШША-дын шинжилгээний тоо аль аль нь буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт №2. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг насны ангилал, хүйсээр нь авч үзвэл:


Он Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	Нийт
Эрэгтэй	9017	8805	8804	8055	7481	42162
Эмэгтэй	6371	5822	5813	5477	4446	27929
Нийт	15388	14627	14617	13532	11927	70091



Он Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	Нийт
0-1 нас	0	68	12	21	13	114
1-4 нас	268	201	203	220	136	1028
5-9 нас	417	366	464	335	237	1819
10-14 нас	493	505	591	478	383	2450
15-19 нас	1089	1004	1048	957	896	4994
20-24 нас	2006	1865	1859	1620	1523	8873
25-29 нас	2937	2687	2253	2018	1675	11570
30-34 нас	2465	2470	2345	2325	2081	11686

35-39 нас	1693	1637	1857	1651	1572	8410
40-44 нас	1370	1245	1288	1250	1110	6263
45-49 нас	931	882	935	919	822	4489
50-54 нас	733	669	713	727	583	3425
55-59 нас	481	480	529	494	433	2417
60-64 нас	247	272	265	279	274	1337
65-аас дээш	258	276	255	238	189	1216
Бүгд	15388	14627	14617	13532	11927	70091

График №2. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг насны ангиллаар графикт дүрсэлбэл:




Бид сүүлийн 5 жилд Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоон үзүүлэлтийг судлахад нийт 70091 хүнд шинжилгээ хийсэн байх ба 60.1% нь эрэгтэйчүүдэд, 39.9% нь эмэгтэйчүүдэд хийгджээ. Насны хувьд 25-29 ба 30-34 насны хүмүүс хамгийн өндөр буюу 16.5% ба 16.7%-ийг эзэлж байна

Хүснэгт №3. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг төрлөөр нь авч үзвэл

Он/ Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	Нийт
Мохоо зүйлийн үйлчлэл	10661	10134	9409	7685	6858	44747
Хурц ир үзүүртэй зүйлийн үйлчлэл	295	347	312	355	486	1795
Зам тээврийн осол	3588	2875	3671	3076	2324	15534
Бусад шалтгаан	844	1271	1225	2416	2259	8015
Бүгд	15388	14627	14617	13532	11927	70091

График №3. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг төрлөөр нь графикаар дүрсэлбэл:




Гэмтлийн зэрэг тогтоосон шинжилгээг гэмтэл үүсгэсэн хүчин зүйл, төрлөөр нь судлахад мохоо зүйлийн үйлчлэлээр үүссэн гэмтэл дийлэнх буюу 63.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт №4. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг зэргээр нь авч үзвэл

Үзүүлэлт \ Он	2017	2018	2019	2020	2021	Нийт
Хүнд зэрэг	836	762	768	681	599	3646
Хүндэвтэр зэрэг	1425	1509	1515	1401	1093	6943
Хөнгөн зэрэг	9380	8330	7822	7168	6313	39013
Гэмтлийн зэрэгт хамаарахгүй	1920	2092	2770	2612	2659	12053
Гэмтэлгүй	1827	1934	1742	1670	1263	8436
Бүгд	15388	14627	14617	13532	11927	70091

График №4. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг зэргээр нь графикт дүрсэлбэл:




Дээрх хүснэгтийн тоон үзүүлэлтээс харахад Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоосон 70091 шинжилгээг гэмтлийн зэрэг тогтоосон байдлаар нь авч үзвэл хамгийн өндөр буюу 55.7% нь Хөнгөн зэргийн гэмтэл, 9.9% нь хүндэвтэр зэргийн гэмтэл, 5.2% нь хүнд зэргийн гэмтэл гэж тогтоогдсон бол 29.2% нь гэмтлийн зэрэгт хамаарахгүй гэмтэл ба гэмтэл тогтоогдохгүй байна гэсэн дүгнэлт гарсан байна.

Хүснэгт №5. Аймгуудын ШША-нд хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг зэргээр нь авч үзвэл:


Он Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	Нийт
Хүнд зэрэг	566	545	583	519	438	2651
Хүндэвтэр зэрэг	939	927	872	828	659	4225
Хөнгөн зэрэг	5668	5163	4695	4512	4177	24215
Гэмтлийн зэрэгт хамаарахгүй	2884	3411	3588	3604	3146	16633
Гэмтэлгүй	2489	2820	2783	2924	2602	13618
Бүгд	12546	12866	12521	12387	11022	61342

График №5. Аймгуудын ШША-нд хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг зэргээр нь графикт дүрсэлбэл:



Графикаас харахад Аймгуудын шүүхийн шинжилгээний албатуудад хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоосон 61342 шинжилгээг гэмтлийн зэрэг тогтоосон байдлаар авч үзвэл хамгийн өндөр буюу 39.8% нь Хөнгөн зэргийн гэмтэл, 6.9% нь хүндэвтэр зэргийн гэмтэл, 4.3% нь хүнд зэргийн гэмтэл гэж тогтоогдсон бол 49% нь гэмтлийн зэрэгт хамаарахгүй гэмтэл ба гэмтэл тогтоогдохгүй байна гэсэн дүгнэлт гарчээ.

График №6. Улаанбаатар хотод гарсан Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг нийслэлийн 9 дүүргийн цагдаагийн газар, хэлтсээр нь графикаар дүрсэлбэл:



Графикт үзүүлснээр сүүлийн 5 жилийн хугацаанд Улаанбаатар хотод гарсан Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг нийслэлийн 9 дүүргийн цагдаагийн газар, хэлтсээр нь судалж үзэхэд Баянзүрх дүүргийн болон Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газрууд өндөр үзүүлэлттэй байна.

Дүгнэлт

1. ШШҮХ-ийн шинжилгээний сүүлийн 5 жилийн материалыг судлахад Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн болон Шүүх эмнэлгийн шинжилгээний газар, 21 аймгийн шүүхийн шинжилгээний албадад хийгдсэн нийт шинжилгээ, хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоог 2017 оныхтой харьцуулахад 2021 онд буурсан үзүүлэлттэй байна.
2. Сүүлийн 5 жилд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд нийт 327147 шинжилгээ хийгдсэн байна. Үүнээс 188629 шинжилгээ буюу 57.7% нь Шүүх эмнэлгийн шинжилгээ байгаа нь хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн гаралт их байгаатай холбоотой гэж үзлээ. Мөн тухайн шинжилгээний 56% нь Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт, 44% нь аймгуудын шүүхийн шинжилгээний албатуудад хийгдсэн байгааг харахад Улаанбаатар хотод хүн амын тоо, төвлөрөл ихтэй байгаагаас гэмт хэргийн гаралт их байгааг илтгэж байна.
3. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоон үзүүлэлтийг харьцуулан судлахад

нийт шинжилгээнд хамрагдагсдын 60.1%-ийг эрэгтэйчүүд эзэлж байна. Насны хувьд 30-34 насныхан 16.7%, 25-29 насныхан 16.5%-тай байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй гарчээ. Шинжилгээнд хамрагдагсдын дийлэнх нь эрэгтэйчүүд ба 25-34 насныхан байгаа нь залуучуудын дунд архидалт, ажилгүйдэл, нийгмийн бухимдал их байгаагаас үүдэлтэй гэж үзэж байна.

4. Шинжилгээнд хамрагдагсдын гэмтлийн шалтгаан, гэмтээгч хүчин зүйл, төрлийг авч үзвэл мохоо зүйлийн үйлчлэлээр гэмтсэн тохиолдол 63.8%, зам тээврийн ослын улмаас гэмтсэн тохиолдол 22.2%-ийн эзэлж байна.
5. Шүүх эмнэлгийн шинжилгээний газар болон аймгуудын шүүхийн шинжилгээний албадад хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг харьцуулан судлахад ШЭШГ-т нийт шинжилгээний 56%, аймгуудын ШША-нд 73.8%-д нь гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ хийжээ. Эндээс дүгнэхэд хөдөө орон нутагт архидалт, ажилгүйдэлтэй холбоотой хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн гаралт их байна гэж үзлээ. Гэмтлийн зэрэг тогтоосон байдлаар нь авч үзвэл гэмтлийн Хөнгөн зэрэг тогтоосон шинжилгээ Улаанбаатар хот болон аймгуудад өндөр хувьтай /55.7%, 39.8%/ байх ба ШЭШГ-т 29.2% нь, аймгийн ШША-дад 49% нь гэмтлийн зэрэгт хамаарахгүй гэмтэл болон гэмтэл тогтоогдоогүй гэсэн дүгнэлт гарсан байна.
6. Сүүлийн 5 жилийн хугацаанд Улаанбаатар хотод гарсан Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг нийслэлийн 9 дүүргийн цагдаагийн газар, хэлтсээр нь судалж үзэхэд Баянзүрх дүүргийн цагдаагийн газарт 11907 хэрэг буюу 24.7%-ийг, Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газарт 8903 хэрэг буюу 18.5%-ийг эзэлж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа ба тус дүүргүүдэд хүн амын тоо их, гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа нь харагдаж байна.

---o0o---